

**“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019 оны 04 сарын 26 -ны өдөр

Дугаар 19/01

Улаанбаатар хот

АПУ ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15 хороо, Махатма Гандийн гудамж 39, Корпорейт Хотел энд Конвеншн Цэнтрийн 4 давхарт байрлах Концертын танхимд 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 14:00 цагт эхлэв.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан хурлын ирцийн мэдээг танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэгийг индэрт урив.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэгийн танилцуулснаар:

Компанийн 1,017,219,991 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 383 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрхтэй 1,062,974,743 ширхэг энгийн хувьцааны 95.695 хувийг төлөөлсөн хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дахь заалт, Компанийн Дүрмийн 7-р зүйлийн 7.11-д заасныг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын агуулгыг танилцуулаад, хурлын даргаар томилогдсон Компанийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг болон Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ж.Үнэнбат, ТУЗ-ийн гишүүнд шинээр нэр дэвшигч Я.Дамдинсүрэн, Томас Холланд нарыг тайзнаа урилаа.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын дарга 1-р хэлэлцэх асуудлыг танилцуулах (30 минут), үүнд:
 - I. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. 1-р асуудалтай холбогдсон асуулт, хариулт (20 минут)

3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 2-р хэлэлцэх асуудлыг танилцуулах (10 минут), үүнд:
 - II. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
4. 2-р асуудалтай холбогдсон асуулт, хариулт (10 минут)
5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 3-р хэлэлцэх асуудлыг танилцуулах (10 минут), үүнд:
 - III. Компанийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох
6. 3-р асуудалтай холбогдсон асуулт, хариулт (10 минут)
7. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга 3-р хэлэлцэх асуудлыг танилцуулах (20 минут), үүнд:
 - IV. Компанийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох
8. 4-р асуудалтай холбогдсон асуулт, хариулт (10 минут)
9. Саналын хуудас бөглөх санамж өгөх (5 мин)
10. Хэлэлцэх асуудлуудаар саналын хуудас бөглөж өгөх (20 минут)
11. Тооллогын комисс санал тоолох үйл ажиллагааг явуулах (30 мин)
12. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах (5 мин)
13. Хурлыг хаах

Хэлэлцсэн нь:

- I. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав [Тайланг хавсаргав]. Энэхүү хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт байвал чөлөөтэй асууна уу гэв.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Дашзэвэг:

1. Нийт борлуулалтын хэдэн хувийг гадаад борлуулалт эзэлж байна? Түүнийг нэмэгдүүлэх төлөвлөгөө юу байна?
2. Хөдөлмөрийн бүтээмжийн талаар тайлбарлана уу. Мөн ажиллагсдын цалин нэмэх боломж бий юу? Ажиллагсдын цалинг 2000 доллар хүргэхийн төлөө ажиллах хэрэгтэй.
3. Хувьцааны үнэ 11,9% өсөж, нэгж хувьцаанд ногдох ашиг 64% өссөн ийм дүнтэй хувьцаа байхгүй учир та бүхэнд баяр хүргэе. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ихэнх нь ахмадууд байгаа тул цаашдаа шинэ залуу үеийг хувьцаа эзэмшигчээр олноор элсүүлэх арга хэмжээ авмаар байна. Хувьцааг ажилтнууд болон оюутнуудад эзэмшүүлэхэд хамтарч ажиллах санал байна.

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг:

1. Бид 2018 онд 2 удаа хувьцаа эзэмшигчдийн хурал хийсэн. Үүгээр танилцуулсны дагуу экспортыг нэмэгдүүлэх 5 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Бид БНХАУ, ОХУ-ыг экспортын голлох зах зээлээ болгон, БНХАУ руу шар айраг, ОХУ руу архин төрлийн бүтээгдэхүүнийг түлхүү экспортлох бодлого баримталж байна. Ирэх 5 жилийн хугацаанд экспортын борлуулалтыг нийт борлуулалтын 20-30%-д хүргэх зорилт тавин ажиллаж байна.
2. Бид бүтээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд 10-аад тэрбум төгрөгийн хэмнэлт хийж чадсан. Компанийн ажиллагсдын дундаж цалин 1.9 сая төгрөг ба өмнөх жилийнхээс 20 гаруй хувь нэмэгдсэн үзүүлэлт юм. Бид 3 жилийн стратеги төлөвлөгөөгөө баталсан ба түүний дагуу цалинг үе шаттай нэмэх болно.
3. Энэ асуудлаар Санхүү эрхэлсэн захирал Г.Энхбилэгтэй холбогдож болно.

Хувьцаа эзэмшигч Алтангэрэл: Компанийн гүйцэтгэх удирдлагын 10 захиралд болон үйлчлэгчид, нийт ажиллагсдад талархал илэрхийлье. Бид үе уламжлан АПУ компанийнхаа хувьцааг эзэмшиж ирсэн, цаашид ч үр хүүхдүүддээ өвлүүлж үлдээнэ гэдгээ хэлье. Та бүхэндээ маш их баярлаж явдаг.

Хувьцаа эзэмшигч: Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний зардлыг багасгах тал дээр ямар төлөвлөгөө байна вэ?

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Хайнекен компанийн хувьд үйл ажиллагаа тасралтгүй байхад ихээхэн анхаардаг соёлтой. Манай компанийн хувьд 1 хектолитр тутам дахь засвар үйлчилгээний зардал 1.7 ам.доллар байдгийг 2.5-3.0 ам.доллар болгож өсгөх зөвлөмж өгсөн. Энэ нь гүйцэтгэл, үйл ажиллагааны тасралтгүй байдалд ихээхэн ач холбогдолтой юм.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Өөр асуулт байна уу?

Асуулт байсангүй.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: АПУ групп компани 2018 онд зах зээлд тэргүүлэгчийн байр сууриа бататгаж, ашиг орлогоо өсгөн амжилттай ажилласан хэмээн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) дүгнэсэн болно.

Хэлэлцсэн нь:

II. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болсон үндэслэл нь:

- Монгол Улсын Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт "Нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа бөгөөд компанийг нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт

орох шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-аар компанийг нэгтгэх тухай шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг баталж болно" гэж заасан байдаг.

- АПУ ХК нь хэд хэдэн охин компанийг нэгтгэсэн, нэгдлийн зохион байгуулалттай толгой компани юм. Компанийн менежментийн үр ашгийг сайжруулах зорилгоор өөрийн эзэмшлийн охин компанийг өөртөө нэгтгэх замаар өөрчлөн зохион байгуулах, ийнхүү өөрчлөн байгуулснаар толгой компанийн хувьцааны тоо ширхэг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, Дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд тус шийдвэрийг гаргах бүрэн эрхийг Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу ТУЗ-д олгох зохицуулалтыг Дүрэмд зааж өгөх шаардлага үүссэн.
- Ийнхүү тус хуулийн заалтыг Дүрэмд тусгайлан зааж өгснөөр, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой болгох ач холбогдолтой.

Дүрмийн нэмэлт өөрчлөлтийн төслийн агуулга:

1. Дараах заалтад доорх байдлаар нэмэлт өөрчлөлт оруулах:

- 1.1. 7.6. Дор дурьдсан асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

- 7.6.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах

гэснийг

- 7.6. Дор дурдсан асуудлыг энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

- 7.6.2. Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5-д зааснаас бусад нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах

гэж өөрчлөх;

- 1.2. 7.16. Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр Хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Харин ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорхи асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно.

- 7.16.1. Компанийн Дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах;

- 7.16.2. Компани нийлүүлэх, нэгтгэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх

гэснийг

7.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр Хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорх асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно. Үүнд Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5, энэхүү дүрмийн 7.22.21-т заасны дагуу нэгтгэх замаар өөрчлөн байгуулах асуудал хамаарахгүй болно.

7.16.1. Компанийн Дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах;

7.16.2. Компани нийлүүлэх, нэгтгэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх

гэж өөрчлөх;

1.3. 7.22.21 гэж нэмэлт заалт оруулах

7.22. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ дүрмээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.22.21. Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5-д заасны дагуу компани нийт энгийн хувьцааны 75 хувиас дээш хувийг эзэмшдэг өөрийн охин компаниа нэгтгэх, ийнхүү нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд уг компанийг нэгтгэх тухай шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг батлах;

2. Дээр заасан нэмэлт өөрчлөлтөөс бусад Дүрмийн зүйл, заалтууд хүчин төгөлдөр, хэвээр үлдэнэ.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Дээрх асуудалтай холбоотой асуулт байвал чөлөөтэй асууна уу.

Асуулт байсангүй.

Хэлэлцсэн нь:

III. Компанийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болсон үндэслэл нь:

- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аас 2019.04.04-ний өдрөөр тасалбар болгон гаргасан, Үнэт цаас эзэмшигчдийн судалгааны мэдээллээр Компанийн хувьцааны 13.42%-ийг эзэмшигч Steppe Beverage KFT компани

ТУЗ-д төлөөллөө оруулах хүсэлтээ ирүүлсэн учир ТУЗ-ийг шинээр сонгох шаардлага гарсан.

- Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу 77 дугаар зүйлийн 77.3-д заасны дагуу ТУЗ-ийг кумулятив аргаар сонгосон бол түүний бүрэлдэхүүнд өөрчлөлт орох шаардлага үүссэн үед бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас өмнө бүрэн эрхийг дуусгавар болгож, шинэ бүрэн бүрэлдэхүүнийг сонгох зохицуулалттай юм.

Асуулт байна уу?

Асуулт байсангүй.

Хэлэлцсэн нь:

IV. Компанийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох

Танилцуулсан нь:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулав. ТУЗ-ийн ердийн гишүүнд Пүрэвийн Батсайхан, Бүрэнтогтохын Батбаяр, Сергей Громов, Ядамдоржийн Дамдинсүрэн, Кеннет Чу, Томас Холланд нар, хараат бус гишүүнд Өлзийдэлгэрийн Батбаяр, Ёндон-Ойдовын Гэрэлчулуун, Жигжидийн Үнэнбат нар нэр дэвшив.

Нэр дэвшигчидтэй холбоотой асуулт байна уу?

Асуулт байсангүй.

ТУЗ-ийн гишүүдийг сонгох кумулятив аргын талаар тайлбар, саналын хуудас бөглөх зааварчилгаа өгөв.

Асууж тодруулах зүйл байвал асууна уу.

Асуулт байсангүй.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Санал хураалт 30 минутын хугацаанд явагдах тул Ард Капитал ҮЦК-ийн гүйцэтгэх захирал, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр та бүхэнд товч сургалт, танилцуулга хийнэ.

Ард Капитал ҮЦК-ийн гүйцэтгэх захирал, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны удирдах зөвлөлийн дарга Б.Өлзийбаяр “Хөрөнгө оруулалт ба арилжааны сэтгэл зүй” сэдэвт товч сургалт явуулав.

Санал хураалт явагдав.

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга Д.Шүрэнцэцэг: Санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

Хуралд 1,017,219,991 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 383 хувьцаа эзэмшигч оролцсон. Үүнээс 1,016,622,106 ширхэг хувьцаатай 323 хувьцаа эзэмшигч саналын хуудас ирүүлж, үлдсэн 597,885 ширхэг хувьцаатай 60 хувьцаа эзэмшигч саналын хуудсаа ирүүлээгүй байна.

Хурлын 1, 2, 3 дугаар хэлэлцэх асуудлаар саналын хуудас ирүүлсэн хувьцаа эзэмшигчдээс 1,016,481,688 ширхэг хувьцаа эзэмшиж буй 272 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчин төгөлдөр байсан бол үлдсэн 140,418 ширхэг хувьцаатай 51 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчингүй байв.

Хурлын 4 дүгээр асуудлаар 1,016,267,688 ширхэг хувьцаа эзэмшиж буй 199 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчин төгөлдөр, үлдэх 354,418 ширхэг хувьцаа эзэмшиж буй 124 хувьцаа эзэмшигчийн саналын хуудас хүчингүй байв.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах:

Зөвшөөрсөн – 1,016,481,640 ширхэг хувьцаа буюу 99.999995%

Татгалзсан – 48 ширхэг хувьцаа буюу 0.000005%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

2. Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах:

Зөвшөөрсөн – 1,016,466,456 ширхэг хувьцаа буюу 99.998502%

Татгалзсан – 228 ширхэг хувьцаа буюу 0.000022%

Түдгэлзсэн – 15,004 ширхэг хувьцаа буюу 0.001476%

3. Компанийн ТУЗ-ийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох:

Зөвшөөрсөн – 1,016,478,807 ширхэг хувьцаа буюу 99.999717%

Татгалзсан – 1,102 ширхэг хувьцаа буюу 0.000108%

Түдгэлзсэн – 1,779 ширхэг хувьцаа буюу 0.000175%

Хурлаар дараах асуудлуудыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

4. Компанийн ТУЗ-ийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох

Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнийг сонгох

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	П.Батсайхан	871,483,317	14.29%
2	Б.Батбаяр	869,369,060	14.26%
3	Сергей Громов	869,279,214	14.26%
4	Я.Дамдинсүрэн	869,216,518	14.26%
5	Кеннет Чу	869,417,646	14.26%
6	Томас Холланд	1,748,840,373	28.68%

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох

№	Нэр дэвшигч	Саналын тоо	Хувь
1	Ө.Батбаяр	1,015,410,363	33.305%
2	Ё.Гэрэлчулуун	1,015,093,851	33.295%
3	Ж.Үнэнбат	1,018,298,850	33.400%

Хурлын шийдвэр:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. АПУ ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. АПУ ХК-ийн Дүрэмд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулж, хавсралтаар батлав.
 - 2.1. 7.6. Дор дурдсан асуудлыг энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
 - 7.6.2. Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5-д зааснаас бусад нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 2.2. 7.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдахгүйгээр Хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорх асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно. Үүнд Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5, энэхүү дүрмийн 7.22.21-т заасны дагуу нэгтгэх замаар өөрчлөн байгуулах асуудал хамаарахгүй болно.
 - 7.16.1. Компанийн Дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах;

7.16.2. Компани нийлүүлэх, нэгтгэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх;

2.3. 7.22. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ дүрмээр Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7.22.21. Компанийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.5-д заасны дагуу компани нийт энгийн хувьцааны 75 хувиас дээш хувийг эзэмшдэг өөрийн охин компаниа нэгтгэх, ийнхүү нэгтгэснээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй тохиолдолд уг компанийг нэгтгэх тухай шийдвэр гаргаж, нэгтгэх журмыг батлах;

2.4. Өөрчлөгдсөнөөс бусад дүрмийн зүйл, заалтууд хэвээр болно.

2.5. Дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэгт даалгав.

3. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгов.

4. АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаагаар сонгов. Үүнд:

Ердийн гишүүн

1. П.Батсайхан
2. Б.Батбаяр
3. Сергей Громов
4. Я.Дамдинсүрэн
5. Кеннет Чу
6. Томас Холланд

Хараат бус гишүүн

1. Ө.Батбаяр
2. Ё.Гэрэлчулуун
3. Ж.Үнэнбат

ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсон хүмүүстээ баяр хүргэж, хурлыг зохион байгуулсан залуустаа, хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ талархсанаа илэрхийлье.

Ээлжит хурлыг хаав.

Хурал 16 цаг 10 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛС

APU COMPANY
Absoluta. Pure. Unique.

Ч.Ариунсан

ХЯНАСАН:

Хурлын дарга

АПУ ХУВЬЦААТ КОМПАНИ
27.03.13 21116224557

Ц.Эрдэнэбилэг